

Т ШИНЭ ТАРИАЛАНЧ

МОНГОЛЫН ТАРИАЛАНЧДЫН СЭТГҮҮЛ

2016. №01 (9)



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН
ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**



Цаг агаар

**ТАРИАЛАНГИЙН БҮС НУТГИЙН
2015 ОНЫ ЗУН, ӨВЛИЙН ЦАГ АГААРЫН
БАЙДЛЫН ТОЙМ**

*ХХААЯ-ны Газар тариалангийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Ц. Болорчулуунтай хийсэн ярилцлага.*

**ХӨГЖЛИЙН БАНКИЙГ Л
ХҮЛЭЭЖ БАЙНА**



МОНГОЛ ОРНЫ ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН АШИГЛАЛТ БА ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМИЙН ЗАРИМ ОНЦЛОГ

Я.Баасандорж

ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн газрын нөөц,
газар ашиглалтын салбарын эрхлэгч, хөдөө аж ахуйн ухааны доктор

Хураангуй

Байгалийн унаган тогтоц, эмзэг байдалд тохируулан Монголчууд мал аж ахуйн үйлдвэрлэлийг олон мянган жилийн тэртээгээс эрхлэн хөгжүүлсэн бөгөөд бэлчээрийн зориулалтаас бусад газар ашиглалт хэлбэр хөгжих боломж байгаль уур амьсгалын нөхцлөөс шалтгаалж хязгаарлагдмал байсан боловч хүн төрөлхтний хөгжлийн чиг хандлагатай уялдаж ХХ зууны хоёрдугаар хагасаас эхлэн газар ашиглалтын уламжлалт арга өөрчлөгдөж нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагын дагуу хот

тосгон, уул уурхайн болон газар тариалангийн зориулалтаар газрыг ашиглах болсоноор ард иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, улс орны эдийн засгийн хөгжлийг түргэсгэхэд чухал алхам болсон бөгөөд энэ хэв маяг цаашид ч үргэлжлэн өргөжих нь боломжтой.

Түлхүүр үг: газар ашиглалт, хөрсний үржил шим, механик бүрэлдэхүүн, талбайн хэмжээ

Оршил

Монгол улс харьцангуй өргөн уудам нутаг дэвсгэртэй боловч эх газрын эрс тэс уур амьсгалтай,

хөрсний үржил шимээр ядуу, ургалтын хугацаа богино, тачир сийрэг ургамал нөмрөгтэй. Ийм тогтоцтой газар нутгийг улс орныхоо хөгжил дэвшил, ард иргэдийнхээ амьдралын сайн сайханы төлөө зориулан хөгжихөд газрыг зөв зохистой ашиглан хамгаалах нь өнөө үеийнхэний тулгамдсан олон асуудлуудын нэг юм. Газар нутаг нь байгалийн унаган төрхөө хадгалсан давтагдашгүй үзэсгэлэнтэйгээрээ бахархал болдог төдийгүй манай ард түмний аж амьдрал, зан заншилд эх болсон газар шороогоо хайрлан хамгаалах, зөв зохистой ашиглах талаар гүнзгий шингэсэн уламжлалтай.